## “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
## 2020 ОНЫ 08 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2020 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1. | 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1 | - “Мон – Энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын цахилгаанаас бусад хэсгийг дуусгасан ба 08 дугаар сарын 10-ны өдөр Барилга хөгжлийн төвийн Чинсанаа дарга дээр “Мон-энержи Консалт” ХХК-ийн удирдлага, паркийн Ахлах мэргэжилтэн нар паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг дуусгах асуудлыг хэлэлцэж дараах арга хэмжээнүүдийг шийдвэрлэхээр тогтосон. Үүнд:<br>➢ ЭХЯ-наас цахилгаан хангамжийн техникийн нөхцөл шинэчлэн батлагдсаны дараа Багануурт зураг төсөл гүйцэтгэгч болон захиалагч байгууллагуудын уулзалтыг газар дээр нь зохион байгуулж, цахилгаан хангамжийн техникийн зургийг гаргах<br>➢ “Мон – Энержи Консалт” ХХК зураг төслийн ажлыг 90% дуусгасантай холбогдуулан төслийн санхүүжилтийн үлдэгдэл 200 сая төгрөг авах саналаа БХБЯ, Сангийн яаманд тавих<br>08 дугаар сарын 12-ны өдөр ЭХЯ-наас Шинээр гүйцэтгэх Б1/2020/87 паркийн цахилгаан хангамжийн техникийн нөхцлийг албан ёсоор хүлээн авсан ба Барилга хөгжлийн төвийн эксперт, инженер, “Мон – Энержи Консалт”, “МЕСЕС” ХХК-ийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, мөн паркийн удирдлага нарын оролцсон уулзалтыг 08 дугаар сарын 18-ны өдөр Багануурт зохион байгуулж дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:<br>- Техникийн зургийг тодотгох,<br>- Уурхайн эзэмшил газар, төмөр зам хөндлөн гарах цэгүүдийг тодруулах,<br>- “Мон-энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэх бүсүүдийн цахилгаан хангамжийн схемийг тогтох<br>Одоогийн байдлаар “Мон – Энержи Консалт”, “МЕСЕС” ХХК нь ЦДӨХАШ-ын трассын зургийг боловсруулан дүүргийн Газрын албаар баталгаажуулах бэлтгэл ажлыг хангаж байна. | 100% |
| 2. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | Үйлдвэрлэл, технологийн парк, МЕСЕС ХХК-тай хамтран төв станцаас нэг трассаар 110кВ-ын 2 хэлхээт зураг төсөл боловсруулах техникийн нөхцөл авах асуудлыг 08 дугаар сарын 05-ны өдөр ЭХЯ-нд дахин тавив. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | | “MECEC” XXK, “Мон энержи Консалт” XXK шинэ техникийн нөхцлөөр зураг төсөл хийх ажлыг эхлүүлсэн. | 100% |
| 4. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж | “Нутаг консалтинг” XXK-ийн Үйлдвэрийн албан конторын барилгын батлагдсан зураг төсөл, төсвийг судлав. | 100% |
| 5. | БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө | Байгууллагын хөгжлийн II дунд хугацааны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарсан тул батлуулах хугацааг хойшлуулав. | 90% |
| 6. | Гүйцэтгэлийн зорилт 3.2.4.1 | Паркийн үйл ажиллагаагаар холбогдох БОАЖЯ, БХБЯ, БШУЯ, ХХААХҮЯ-уудтай хамтран ажиллах чиглэлийн саналын төслийг 08 дугаар сарын 06-ны өдрийн 140, 141, 142, 143 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн.<br>Уг албан бичгийн дагуу ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулах газраас 08 дугаар сарын 13-ны өдөр цаг товлож, хамтран ажиллах уулзалтыг 08 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Уулзалтад ХХААХҮЯ-ны газрын дарга нар, НШУҮИГ-ын болон хэлтсийн дарга, паркийн удирдлага холбогдох мэргэжилтнүүдийн хамт оролцон харилцан мэдээлэл солилцож цаашид хамтран ажиллах хамтын ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулж, газрын дарга нараар уламжлан төрийн нарийн бичгийн даргад танилцуулж шийдвэрлэхээр болсон. | 100% |
| 7. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар хариутай 3, хариугүй 8 бичиг нийт 11 албан бичиг ирсэн ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад хариутай 1, хариугүй 14 нийт 15 албан бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. | 100% |
| 8. | 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1 | baganuur-itp.mn цахим хуудасны хөгжүүлэлт, баяжилтыг тогтмол хийн, корона вирустэй холбоотой цаг үеийн мэдээллийг тасралтгүй хүргэж байна. | 100% |
| 9. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад үүрэгт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан.<br>Шилэн дансыг хөтөлж, цахим хуудсанд мэдээллийг агуулга, стандартын дагуу байршуулан санхүүгийн 2 дугаар улирлын тайланг 08 дугаар сарын 04-ний өдөр илгээсэн. | 100% |
| | НЭМЭЛТ АЖИЛ | | |
| 10. | Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гарагт zendmaal@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |
| 11. | Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног бүр гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |

| | | |
|---|---|---|
| 12. | Улаанбаатар хотын Ерөнхий менежрийн баталсан хуваарийн дагуу Шарилжгүй Улаанбаатар-5 аяны хүрээнд хуваарьт газрын шарилж устгалын ажлыг 08 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, тайланг 07-ны өдрийн 145 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд хүргүүлэв. | 100% |
| 13. | НШУҮИГ-аас 08 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан паркуудын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээний талаарх уулзалтад танилцуулга бэлтгэн паркийн дарга, захиргааны болон үйлдвэрлэл, технологийн албаны ахлах мэргэжилтнүүд, маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн нар оролцсон. Уулзалтын үеэр НШУҮИГ-ын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 2021 онд төсөвт суулгуулах болон концессоор гүйцэтгүүлэх хөрөнгө оруулалтын саналыг бэлтгэж байна. | 100% |
| 14. | 08 дугаар сарын 12-ны өдөр удирдлага даргын зөвлөлийн хурлыг хийж, тулгамдсан шийдвэрлэх асуудлууд, өнөөгийн ажлын явц, цаашид нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэв. | 100% |
| 15. | НЗДТГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс 08 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “Төслийн удирдлагын үндэс” сургалтын агуулга боловсруулах анхан шатны сургалтад Үйлдвэрлэл, технологийн кластер инженер хамрагдсан. | 100% |
| 16. | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/01 дүгээр тушаалаар баталсан хуваарийн дагуу хичээлийн шинэ жилийг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээнд 08 дугаар сарын 15-ны өдөр оролцов. | 100% |
| 17. | Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсээс 08 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн албан бичгийн дагуу байгууллагын гэр хороололд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг албан хаагчдын судалгааг 08 дугаар сарын 18-ны өдрийн 146 тоот албан бичгээр хүргүүлэв. | 100% |
| 18. | МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хавсралт болох УХОХ-т тусгах төслийн саналыг боловсруулан НШУҮИГ, ҮХГ-т тус тус цахимаар илгээн “Хөрөнгө оруулалтын төслийн нэгдсэн мэдээллийн сан”-г шинэчлүүлэв. | 100% |
| 19. | 08 дугаар сарын 25-ны өдөр НШУҮИГ-т 9 дүгээр сард хамтран ажиллах төлөвлөгөөний санал, холбогдох яамдуудтай хэлэлцэх асуудлуудын төсөл болон нийслэлийн “Жуух бичиг”-ээр шагнуулах 1 албан хаагчийн мэдээллийг тус тус цахимаар хүргэв. | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э. ЭНХЗАЯА